

СОЁЛ

**«МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ»
ХЭЛНИЙ ҮЗҮҮР ШҮДНИЙ,
ХАМЖИХ ГИЙГҮҮЛЭГЧИЙГ
ГАЛИГЛАХ АСУУДАЛД**

**А. Лувсандэндэв
ШУА-ийн сурвалжлагч гишүүн**

«Монголын Нууц Товчооны» хятад галигийг дэлхийн олон улсын эрдэмтэд үлэмжхэн судлаж, тайлан уншихыг оролдсоор байна. Гэвч энэ агуу их зохиол хичнээн их судлах тутам төчнөөн олон шинэ асуудлыг шийдвэрлэхийг шаардаж байна. «Монголын Нууц Товчоог» хятад үсгээр галиглахад ашигласан эх нь уйгуржин монгол үсгээр байв уу, дөрвөлжин үсгээр байсан уу гэдэг асуудал нэгэн тийш болсон гэж бид өнөөдөр итгэлтэй хэлж чадахгүй байна. Хятад галигийн судалгааны өнөөдрийн байдал ийм хариу өгөхөд хүргэж байна. «Монголын Нууц Товчоог» зохиох үед дөрвөлжин үсэг байгаагүй учир анхны эх нь уйгуржин монгол үсгээр байсан гэхэд төдий л алдаа болохгүй биз. Гэвч «Монголын Нууц Товчоог» хятад галигаар буулгах үед төрийн бичиг хэмээгдэх дөрвөлжин үсгийн «Монголын Нууц Товчоо» байсан нь гарцаагүй биз. Хятад галигаар буулгагчид энэ хоёр эхийн чухам алийг нь ашиглах гэдэг эрдэм шинжилгээний үүднээс ч багагүй сонирхолтой асуудал юм. Гэвч үүнээс чухал бөгөөд амжилтад хүрч болох асуудал бол уг зохиолыг бичсэн дунд үеийн монгол хэлээр эхийг сэргээх явдал юм.

«Монголын Нууц Товчооны» эхийг дунд үеийн монгол хэлээр сэргээн галиглахтай холбогдон олон асуудал гарч ирнэ. Тэдгээрийн нэг нь хэлний үзүүр шүдний, хамжих, сул гийгүүлэгчийг үгийн эцэст хэрхэн галиглах вэ гэдэг асуудал байна. Э. Хейниш «» тэмдгээр, жишээлбэл: külu'ut «хүлэгүүд», ko'ut «хүвгүүд»¹, ejet «эээд»,² sünit «шөнөд»³, nohot «нугасууд»⁴, halao ut «галууд»⁵, uru'ut «ургууд»⁶, okit «охид»⁷, hatut «хатад»⁸, usuget «өчүүхэн»⁹ гэх мэтийн үгэнд, Л. Лигети Мөн «t» үсгээр, жишээлбэл: köut¹⁰, kulu' ut¹¹, ejet¹², sönit¹³, nogot¹⁴, qalawut¹⁵, uru' ut¹⁶, ükit¹⁷, qatut¹⁸, ucuget¹⁹ гэх мэтчилэн, И.де Рахевильтц t тэмдгээр, жишээлбэл: külü üt²⁰, köüt²¹, ejet²², sönit²³, noqot²⁴, qalawut²⁵, uru'ut²⁶, okit²⁷, qatut²⁸, ücüket²⁹ гэх мэтийн үгэнд үгийн эцсийн хэлний үзүүр шүдний хамжих гийгүүлэгчийг тус тус галиглажээ. Харин Ш. Озава «d» үсгээр галиглажээ.

¹ Wörterbuch zu Monghol un niuca tobca an (Yüan-ch' ao pishi) Geschichte der Mongolen von Erich Haenisch, Wiesbaden, 1962, 105-р

² Мөн тэнд, 42-р тал, ³ Мөн тэнд, 138-р тал, ⁴ Мөн тэнд, 118-р тал, ⁵ Мөн тэнд, 56-р тал, ⁶ Мөн тэнд, 167-р тал, ⁷ Мөн тэнд, 122-р тал, ⁸ Мөн тэнд, 63-р тал. ⁹ Мөн тэнд, 158-р тал,

¹⁰ Histoire secrete des Mongols par Lodis Ligeti, Akademiai kiado Budapest, 1971, 18-р тал

¹¹ Мөн тэнд, 15-р тал, ¹² Мөн тэнд, 16-р тал, ¹³ Мөн тэнд, 19-р тал, ¹⁴ Мөн тэнд, 20-р тал, ¹⁶ Мөн тэнд, 24-р тал,

¹⁷ Мөн тэнд, 27-р тал, ¹⁸ Мөн тэнд, 27-р тал. ¹⁹ Мөн тэнд, 32-р тал,

²⁰ Igor de Rachewiltz, Index to the Sesret History of the Mongols Bloomington 1972, 13-р тал

²¹ Мөн тэнд, 14-р тал, ²² Мөн тэнд, 14-р тал, ²³ Мөн тэнд, 16-р тал, ²⁴ Мөн тэнд, 17-р тал, ²⁵ Мөн тэнд, 17-р тал,

²⁶ Мөн тэнд, 21-р тал, ²⁷ Мөн тэнд, 23-р тал ²⁸ Мөн тэнд, 23-р тал, ²⁹ Мөн тэнд, 27-р тал,

Жишээлбэл: kulu' üd³⁰, kö ud³¹, ejed³², sönid³³, nogod³⁴ Galaud³⁵, uru' ud³⁶, okid³⁷, gatud³⁸, uçuged³⁹ гэх мэтчилэн. «Нууц Товчоог» судалсан эрдэмтэд тухайн байрлалд орших хэлний үзүүр шүдний хамжих гийгүүлэгчийг ингэж хоёр өөрөөр галигладгийн учир юунд байна? Эртний монгол хэлэнд дуугүй чанга гийгүүлэгч үлэмж хэрэглэгдэж байсан нь баталгаа шаардахгүй үнэн, тиймээс дундад үед ч дуугүй чанга гийгүүлэгч давамгайлж байж гэж үзвэл Э. Хейниш, Л. Лигети, И. де Рахевильтц нарынх зөв баймаар. Гэтэл Л. Лигети jeüred-ün⁴⁰, nereyidüü⁴¹, ökid-iyen⁴², ökid-i⁴³ И. де. Рахвельтц jeüred-un⁴⁴, nereyidüü⁴⁵, ökid-i⁴⁶, ökid-iyen⁴⁷ гэх мэтчилэн мөнхүү гийгүүлэгчийг эгшгийн өмнөх байрлалд d үсгээр тэмдэглэжээ. Энэ нь үгийн эцэст энэ байрлалд хэлний үзүүр шүдний, хамжих, чанга гийгүүлэгч t биш, хэлний үзүүр шүдний хамжих сул гийгүүлэгч байгаагийн тодорхой гэрч юм. Нөгөө талаар хэлний үзүүр шүдний, хамжих, чанга, дуугүй гийгүүлэгч дунд үеийн монгол хэлэнд дэвсгэрлэдэггүйг Чойжи-Одсэр богд бүр 1305 онд «Зүрхний толт» гэдэг хэл зүйн номдоо тодорхойлсныг бид мэднэ.

Үүнээс үзэхэд Ш. Озавагийн бидний сонирхон бүхий гийгүүлэгчийг d үсгээр галигласан нь зөв гэлтэй. Ингэхлээр Э. Хейниш, Л. Лигети, И. де Рахевильтц нарын зэрэг нэрт монголч эрдэмтэд бидний сонирхон буй гийгүүлэгчийг санал нэгтэй хэлний үзүүр шүдний, хамжих, дуугүй гийгүүлэгч гэж үзээд, t үсгээр тэмдэглээд байдгийн учир юунд байна гэдэг асуудал аяндаа гарч ирнэ. Эдгээр эрдэмтдийн эсрэг, тэсрэг хоёр саналын аль алинд үнэний хувь байна. Ингэхлээр энэ зөрчлийг яаж шийдвэрлэх вэ?

Юуны өмнө дундад үеийн монгол хэлний бусад дурсгалд үгийн эцсийн хэлний үзүүр шүдний хамжих гийгүүлэгчийг хэрхэн тэмдэглэж байсныг авч үзье.

XV зууны үеийн монгол хэлний дурсгал болох «Мукаддимат ал-Адаб» тольд монгол хэлний n гийгүүлэгч, мөн тэрчлэн г гийгүүлэгчээр төгсдөг үгийн үндсэнд залгадаг олон тооны дагаврыг араб цагаан толгой t үсгээр тэмдэглэсэн байна. Жишээлбэл: yabuvan-yabuvat, xatun-zatut, e' ülen-e'ület, qijar - qijat, nökur-nöküt, küken-küket (ni)⁴⁸ г.м.

Монголын дөрвөлжин бичгийн дурсгалын зүйлээс Чавчаалын суварганы бичээсэнд, жишээлбэл: bosqa' a' ad⁴⁹, bö'ed⁵⁰, ki'ed⁵¹, zaranu'ud⁵², noyad⁵³, гэх мэтийн үгэнд дөрвөлжин бичгийн цагаан толгойн үсгээр тэмдэглэсэн байна. Дундад үеийн монгол хэлний эдгээр хоёр чухал дурсгалд хэлний үзүүр шүдний, хамжих гийгүүлэгчийг дээр дурдсан эрдэмтдийн нэгэн адил өөр өөрөөр тэмдэглэсэн байна. Энэ нь үгийн эцсийн хэлний үзүүр шүдний, хамжих гийгүүлэгчийг галиглах тухай асуудал монгол хэлний авиа зүйн өвөрмөц онцлог асуудлын нэг болохыг давхар гэрчилж байна.

³⁰ Sh. Ozaba, Gan chao hi shi zen shyuqu (Монголын Нууц Товчооны» бүрэн судалгаа, япон хэл дээр) I Токио, 1984. 36-р тал

³¹ Мөн тэнд. 101-р тал, ³² Мөн тэнд. 68-р тал. ³³ Мөн тэнд, 118-р тал. ³⁴ Мөн тэнд, 152-р тал. ³⁵ Мөн тэнд, 152-р тал. ³⁶ Мөн тэнд. 199-р тал, ³⁷ Мөн тэнд 224-р тал. ³⁸ Мөн тэнд. 224-р тал. ³⁹ Мөн тэнд. 227-р тал,

⁴⁰ Л. Лигети өмнө дурдсан зохиол, 24-р тал

⁴¹ Мөн тэнд, 27-р тал. ⁴² Мөн тэнд, 30-р тал, ⁴³ Мөн тэнд, 30-р тал.

⁴⁴ И. де Развелт емне дурдсан зохиол, 30-р тал

⁴⁵ Мөн тэнд 23-р тал ⁴⁶ Мөн тэнд. 25-р тал. ⁴⁷ Мөн тэнд, 25-р тал,

⁴⁸ Н. Н. Поппе, Монгольский словарь Мукаддмат ал-Адаб, Москва-Ленинград, 1938, стр. 69

⁴⁹ Н. Н. Поппе, Квадратная письменность Москва-Ленинград, 1941, 84-р тал

⁵⁰ Мөн тэнд. 84-р тал, ⁵¹ Мөн тэнд, 84-р тал. ⁵² Мөн тэнд, 88-р тал,

⁵³ Мөн тэнд. 89-р тал

Бидний сонирхон бүхий асуудлын талаар онцгой ач холбогдолтой хэрэглэгдэхүүн уйгуржин монгол бичигт байна. Уйгуржин монгол бичигт хэлний үзүүр шүдний, хамжих, дуугүй, чанга гийгүүлэгч дэвсгэрлэдэггүй гэдгийг дээр нэгэнт өгүүлсэн билээ. Уйгуржин монгол бичигт үгийн эцэст орсон хэлний үзүүр шүдний, хамжих, сул гийгүүлэгчийг гэдэс, сүүл хоёроос бүтсэн үсгээр тэмдэглэдэг. Жишээлбэл: *külüg-üd, kübegüd, ejed, sönid, yalayud, uguu-ud, ökid, xatud* гэх мэт. Гэтэл уйгуржин монгол бичигт «эд» гэхийг «дэд» гэхийг гэж эцэст орсон хэлний үзүүр шүдний, хамжих, сул гийгүүлэгчийг *daleth* тэмдгээр илтгэсэн байдаг. Энд ямар учир байна?! «эд» гээд бичихэд «он» гэдэгтэй адил болохоос зайлсхийсэн хэрэг гэхэд «дэд» гэж бичиж болох байсан. Бас *noyad* гэхийг *kubegüd* гэхийг *arad* гэхийг тус *pöküd* гэх мэтчилэн хэлний үзүүр шүдний хамжих гийгүүлэгчийг нь гэдгийнхтэй адил бичиж болох байсан. *Хаян-ну bicügsen manju mongyol ügen-nü toli bicig*-т гэдэг үгийг харьяалахын тийн ялгалд *ebüged-ün* гэж нөхцлийг нь салангид бичээгүй, *bügedün* гэж үргэлж, үргэлж бичихдээ бас гэдэс, ацаг хоёроос бүрдсэн тэмдгээр хэлний үзүүр шүдний хамжих гийгүүлэгчийг илтгээгүй, *daleth* үсгээр тэмдэглэсэн байна. гэдэг үгийг заахын тийн ялгалд гэж бичсэн байна⁵⁶. Энэ бол *ebüged* гэхэд хэлний үзүүр шүдний, хамжих, дуугүй, сул гийгүүлэгч, *ebügedün* гэхэд хэлний үзүүр шүдний, хамжих, дуутай сул гийгүүлэгч тус тус байгааг нарийн ажиглаж, ялгаж тэмдэглэсэн нь гарцаагүй мөн. Эдгээр хоёр авиа нь дуутай, дуугүйгээр ялгаатай хоёр өөр авиа мөн. Эдгээр хоёр авиа хэрэг дээрээ авиалбарын үүрэг гүйцэтгэж байжээ. Эртний монгол эрдэмтэд үүнийг ажиглаад, дуутай гийгүүлэгчийг нь үсгээр, дуугүйгийг нь үгийн дунд үсгээр, үгийн эцэст үсгээр тус тэмдэглэжээ.

Хэлний үзүүр шүдний, хамжих, дуугүй, сул гийгүүлэгч нь үгийн эцэст, үгийн дунд чанга гийгүүлэгчийн өмнө байрлалд тохиолдоно. Жишээлбэл: *bürüdcü, duradxal, üyitedtel* гэх мэт. *Odba* гэж бичдэг нь хоёр уруулын гийгүүлэгч энэ байрлалд дунд үеийн хэлэнд төгсвөр нь дуугүй, эртний хэлэнд дуугүй чанга гийгүүлэгч байсны гэрч буй за.

Цаашилбал, эртний монгол эрдэмтэд хэрэгцээтэй гэж үзсэн газраа хэлний үзүүр шүдний, хамжих, дуугүй, сул гийгүүлэгчийн шинж чанарыг хадгалахын тул дуугүй эхэлбэртэй *d* авиатай *du* жийрэг хэ-

⁵⁴ Savji, *Mongyol üsüg-ün dürim-ün toli bičig, Obür Mongyolun öbertegen jasaxu oron-u arad-un jasay-un ordon-u keblel-ün tobciyan-aca dakin keblebei 1951, 67-р тал*

⁵⁵ Мөн тэнд, 665-р тал

⁵⁶ *Хаян-ну bičigsen manju mongyol gen-nü toli bičig, (Оршилд)*

рэглэсэн байна. Жишээлбэл: *duead-duradduysan, bayad-bayad-duysan* г.м. Гэвч *uyiled-uledügsen* гэдэгт хэлний үзүүр шүдний дуугүй гийгүүлэгчийг дуутай болгон тэмдэглэсэн нь өмнө нь орсон авиануудын нөлөө буй. Чойжи-Одсэр «Зүрхний толт» хэмээх номдоо гийгүүлэгчийг гийгүүлэгчээс ялган дэвсгэрийн тоонд оруулсны учир ийм буй.

Ийнхүү «Монголын Нууц Товчооны» үгийн эцэст, мөн тэрчлэн үгийн дунд чанга гийгүүлэгчийн өмнө тохиолдох хэлний үзүүр шүдний хамжих гийгүүлэгч нь дуугүй, сул гийгүүлэгч байна. Байдал иймээс түүнийг *t* үсгээр биш, *d* үсгээр ч биш, *d* үсгээр галиглавал зохино. Өгүүллийн эхэнд иш татсан үгсийн эцэст орсон хэлний үзүүр шүдний, хамжих, дуугүй сул гийгүүлэгчийг нь үсгээр тэмдэглэн галиглах нь: *külü'üd, kö'üd, ejed, sönid, vala'ud, povod uru'ud, ökid, qatud, ücüged*. Мөн тэрчлэн чанга гийгүүлэгчийн өмнөх байрлалд: *hereyidcü* (МНТ, 46-р зүйл), *uduridcu* (МНТ, 54-р зүйл).